

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	12	Өдөр	24
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	“Жолоочийн хариуцлагын сайн дурын нэмэлт даатгал”					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Гүйцэтгэх захирлын тушаал		2022.01.22		ЗТ-22/01-014	
6	Цахимаар борлуулах эсэх	Тийм					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Жолоочийн хариуцлага					
	Даатгалын үндсэн эрсдэл	Гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн өмнө хүлээх хариуцлага					
	Даатгалын нэмэлт эрсдэл	-					
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	1%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Жолоочийн хариуцлагын сайн дурын, нэмэлт даатгалын гэрээний үнэлгээнээс давсан хохирол;
2. Даатгуулагч санаатайгаар хууль бүс үйлдэл, гэмт хэрэг, зөрчилүйдэх явцдаа тухайн тээврийн хэрэгслийг ашигласан бөгөөд түүний улмаас учирсан хохирол;
3. Даатгуулагч согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн болон хэт ядарсан үедээ замын хөдөлгөөнд оролцсоны улмаас учирсан хохирол;
4. Замгүй газраар явсан, уралдаан тэмцээн, ан ав хөөж явснаас үүдсэн хохирол;
5. Зориулалтын бус аргаар тээврийн хэрэгслийг чирэх, чирэгдэх оролдлого хийх болон түрэх, түлхэх оролдлого хийснээс үүдсэн хохирол;
6. Даатгуулагч нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдаагүй, гэрээний хугацаа нь дууссан, гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж дуусгавар болгосон, жолоодох эрхийн үнэмлэхгүй, жолоодох эрх нь хасагдсан үед бусдад учруулсан хохирол болон зам тээврийн ослын хэрэг нь шүүх, прокурор болон цагдаагийн байгууллагаар шалгагдаж байгаа этгээд жолоодсноос үүдсэн хохирол;
7. Даатгуулагч нь тээврийн хэрэгслээ үл хөдлөх буюу өөрөөс нь бусад этгээд хөдөлгөх боломжгүй болгох арга хэмжээ аваагүйгээр орхин явснаас үүдсэн хохирол;
8. Нийтийн эзэмшлийн ил зогсоол болон гаражид тээврийн хэрэгслээ байрлуулсны дараа түлхүүрээ бусдад үлдээн явснаас үүдэн гарсан хохирол;
9. Даатгалын гэрээг цахимаар байгуулсан болон даатгалын зуучлагчаар дамжуулан байгуулснаас хойш 24 цагийн дотор учирсан аливаа хохирол (Хэрэв даатгуулагч даатгалын гэрээгээ сунгасан эсхүл даатгуулагч даатгагчийн салбар нэгж, төв байранд өөрийн биеэр ирж даатгуулсан тохиолдолд уг заалт хамаарахгүй);
10. Даатгуулагч нь даатгалын гэрээний хураамжаа бүрэн болон хэсэгчлэн төлөөгүй байх үед учирсан хохирол.